

У.В. О. Куайн¹⁴⁸ Эмпиризмийн хоёр догм¹⁴⁹

Орчуулсан: Э.Баасандорж, магистр, багш
МУИС, Философи, шашин судлалын тэнхим

Орчин үеийн эмпирицизм хоёр догманы дор олон талаар нөхцөлдөж ирэв. Эхнийх нь баримтаас ангид утгад тулгуурласан аналитик үнэн ба баримтад тулгуурласан синтетик үнэний хооронд ямар нэг суурь шинжтэй зааг бий гэх үнэмшил мөн. Удаах нь редукционизм буюу утга холбогдолтой (meaningful) бодомж бүр шууд туршлагыг заасан нэр томъёонуудын ямар нэг логик бүтэцтэй тэнцүү гэх итгэл үнэмшил юм. Би хоёуланг нь алдаатай болох тухай үндэслэл дэвшүүлнэ. Эдгээрийг орхисноос гарах нэг үр дагавар болж спекулятив метафизик болон байгалийн шинжлэх ухааны дундах зааг бүдгэрнэ гэдгийг бид харах болно. Нөгөө нэг үр дагавар нь прагматизм руу хийх шилжилт мөн.

I. АНАЛИТИК ЧАНАРЫН СУУРЬ НӨХЦӨЛ

Санаануудын харилцаа хийгээд баримтын асуудлын хооронд тавьсан Хьюмийн зааг, оюун ухааны (truths of reason) үнэн хийгээд баримтын үнэний хооронд тавьсан Лейбницийн зааг нь аналитик ба синтетикийн дунд тавьсан Кантын заагийн урьдач болов. Лейбниц оюун ухааны үнэн гэдгийг бүх боломжит ертөнцөд үнэн хэмээн ярьж байв. Чамирхлыг нь орхивол, энэ оюун ухааны үнэн гэдэг бол худал байх бололцоогүй тийм үнэн гэсэн үг юм. Үүнтэй ижлээр бид аналитик бодомж бол үгүйсгэл нь өөртөө-зөрчилтэй байдаг бодомж хэмээн тодорхойлохыг сонссон. Гэхдээ энэ тодорхойлолт нь тайлбарлалын үнэ цэнээрээ ядмаг; учир нь аналитик чанарын энэ тодорхойлолтод шаардлагатай тийм өргөн утга бүхий өөртөө-зөрчилтэй-байдлын тухай ухагдахуунд өөрт нь аналитик чанар хэмээх ухагдахуунтай адилаар тодруулга хийх хэрэгцээ бий.¹⁵⁰ Энэ хоёр ухагдахуун бол нэг зоосны хооронд нь эндүүрмээр хоёр тал мөн. Кант аналитик бодомж гэдгийг ойлголтын хувьд субьектдээ угаас агуулагдаж байснаас илүүг хамаатуулдаггүй бодомж гэж ухан ойлгож байв.

Ийм томъёололд хоёр сул тал байгаа юм: энэ нь субьект-предикатын хэлбэр бүхий бодомжуудаар л хязгаарлагдана, агуулах гэдгийн хувьд метафор түвшиндээ үлдсэн тийм ойлголтод л ханддаг. Гэсэн ч аналитик чанарын талаарх Кантын тодорхойлолтоос илүү уг ухагдахууныг хэрхэн хэрэглэж байснаас нь түүний санаж байсан зүйл илүү илэрхий харагдах ба түүнийг нь ийн илэрхийлж болох юм: аливаа бодомж баримтаас ангид бөгөөд утгынхаа (meaning)¹⁵¹ хувьд үнэн байвал аналитик байна. Үүнийг мөшгөөд, үүнд угтуул санаа (presupposition) болж буй утга хэмээх ойлголтыг шинжиж үзье.

¹⁴⁸ Орчуулагчийн тэмдэглэл: Тус өгүүлэл хоёр өөр хувилбартай. Нэг нь 1951, нөгөө нь 1961 онд хэвлэгдсэн. 1951 оны хувилбар нь дараагийнхаасаа бага зэрэг дэлгэрэнгүй байдаг. Иймд 1951 оны хувилбарыг сонгон орчуулав.

¹⁴⁹ Энэ өгүүллийн ихээхэн хэсэг нь аналитик чанарыг шүүмжлэхэд чиглэсэн бөгөөд энэ шүүмжээ би олон жилийн турш амаар болон бичгээр илэрхийлсээр ирсэн. Энэ тухай хэлэлцэхэд тусалж байсан бусад хүмүүст, тэр дундаа Карнап, Чёрч, Гүдмэн, Тарски, Уайт нарт би үгээр хэлшгүй их өртэй. Уайтын *"Analytic and Synthetic: Untenable Dualism"* (Нью-Йорк, 1950) гэх эсэвдэнд энэ сэдэвтэй холбоотойгоор ярих хэрэгтэй олон зүйлийг дурдсан бий; харин энэ өгүүлэлд би уг асуудалтай холбоотой зарим нэмэлт зүйлийг авч үзэх болно. Анхны ноогийг маань үзээд үнэтэй шүүмж өгсөн Доналд, Л. Дэвидсонд талрхсанаа илэрхийлье.

¹⁵⁰ White, Op. Cit., p. 324-ыг үзнэ үү.

¹⁵¹ Орчуулагчийн тэмдэглэл: Хэлний тухай философид "утга" хэмээн орчуулж болохоор хэд хэдэн нэр томъёо бий. Жишээ нь, Фрегегийн "sinn" хэмээх ойлголтыг англи хэлэнд "sense" хэмээн орчуулдаг. Үүнийг бид ч мөн утга хэмээн орчуулах боломжтой юм. Гэтэл "sense," "meaning" хоёр өөр утга илэрхийлж буй үед ялгаж орчуулах шаардлагатай болдог. Ийм учраас манайд "meaning"-ийг "утга холбогдол", "sense"-ийг "утга" хэмээн орчуулдаг. Уг орчуулгын тухайд, Фрегегийн "sense"-ийг "meaning"-ээс ялгах шаардлага гараагүй учир "meaning" хэмээх үгийг утга хэмээн буулгав.

Утгыг нэрлэхүйтэй адилтгаж болохгүй гэдгийг сануулмаар байна. ‘Үдшийн гялаан’ ба ‘Үүрийн цолмон’-гийн талаарх Фрегегийн жишээг авч үзье. Дахин дахин үзэгддэг хий юм биш харин биет зүйл хэмээн ойлговоос Үдшийн гялаан бол Сугар гараг мөн. Үүрийн цолмон ч үүнтэй ижил. Ганц тоон дээрх хоёр өөр нэр томъёо нэг зүйлийг зааж байна. Гэтэл ‘Үдшийн гялаан = Үүрийн цолмон’ гэх адилсал бол одон орон судлалын ажиглалтад үндэслэн гаргасан баримтын шинжтэй бодомж учраас уг нэр томъёонуудын утгыг ялгаатай хэмээн үзэх ёстой болно. Хэрэв ‘Үдшийн гялаан’ ба ‘Үүрийн цолмон’ хоёр утгын хувьд төсөөтэй байсан бол ‘Үдшийн гялаан = Үүрийн цолмон’ хэмээх адилсал аналитик болох байв.

Мөн ‘Скотт’ болон ‘Ваверлигийн зохиогч’ хоёрын талаарх Расселын жишээ бий. Үгсийн утгад анализ хийх нь ганц тоон дээрх уг хоёр нэр томъёогоор нэг ижил хүн нэрлэгдсэн гэдгийг IV Жеоржод ойлгуулах хангалттай арга яав ч биш байв.

Утга ба нэрлэхүйн зааг нь хийсвэр нэр томъёонуудын хувьд дээрхээс дутахааргүй чухал байдаг. ‘9’ болон ‘нарны аймгийн гарагуудын тоо’ гэх нэр томъёонуудыг нэг ижил нэгж хийсвэр юмыг (abstract entity) нэрлэж байгаа ч утгын хувьд ижил биш хэмээн үзэх ёстой болдог; учир нь энд гарч буй нэгж хийсвэр юмны ижилслийг тогтоохын тулд дан ганц утгыг тунгаах явдал биш давхар одон орон судлалын ажиглалт хэрэгтэй байсан.

Энэ хүртэл бид ганц тоон дээрх нэр томъёонуудыг авч үзлээ. Ерөнхий нэр томъёо эсвэл предикатуудын тухайд нөхцөл байдал тодорхой хэмжээнд ялгаатай авч параллель байна. Ганц тоон дээрх нэр томъёонууд хийсвэр эсвэл бодитой ямар нэг нэгж юмыг нэрлэх зориулалттай байдаг бол ерөнхий нэр томъёо тийм биш; гэхдээ ерөнхий нэр томъёо нь нэгж эсвэл олон юманд үнэнээр хамаатаж эсвэл юунд ч үнэнээр хамаатахгүй байж болно. Ерөнхий нэр томъёонд үнэнээр хамаатах бүх нэгж юмсын ангийг нэр томъёоны багтаамж (extension) гэнэ. Харин ганц тоон дээрх нэр томъёоны утга ба нэрлэгдэж буй нэгж юмны эсрэгцлийг зэрэгцүүлэхдээ бид ерөнхий нэр томъёоны утга хийгээд түүний багтаамжийг мөн адил ялгах учиртай. ‘Зүрхтэй амьтан’, ‘бөөртэй амьтан’ гэх мэт ерөнхий нэр томъёонууд багтаамжийн хувьд төсөөтэй байж болох ч утгын хувьд тийм биш.

Ерөнхий нэр томъёонууд дээр бол утга гэдгийг багтаамжтай хольж хутгах тохиолдол нь ганц тоон дээрх нэр томъёонуудын утга ба нэрлэхүйг хольж хутгах тохиолдол шиг нийтлэг биш. Агуулга (эсвэл утга) гэдгийг багтаамжид эсвэл, өөр үгээр бол коннотацийг денотацид сөргүүлэх нь философид ягшсан зүйл гэдэг нь үнэн.

Мөн чанарын талаарх Аристотелийн ухагдахуун бол агуулга (intension) эсвэл утгын талаарх орчин үеийн ухагдахууны өвөг байсан нь эргэлзээгүй. Аристотелийн хувьд, рационал байх гэдэг нь хүмүүсийн хувьд мөн чанарлаг шинжтэй байсан бол хоёр хөлтэй (two-legged) байх нь тохиолдлын шинжтэй байв. Гэтэл энэ хандлага хийгээд утгын талаарх номлол хоёрын дунд чухал ялгаа бий. Удаах өнцгөөс бол рационал байдал гэдэг нь ‘хүн’ хэмээх үгийн утгад агуулагдсан байхад хоёр хөлтэй байх гэдэг нь тийм биш хэмээн бодож болох нь (зөвхөн үндэслэлдээ зориулж гэвэл) үнэн; гэвч хоёр хөлтэй (two-legged) байх гэдгийг ‘хос хөлтэй’ (biped) гэдгийн утгад агуулагдсан харин рационал байдал гэдэг нь тэгээгүй хэмээн үзэж бас болно. Иймд утгын тухай номлолын үүднээс бол рационал бөгөөд хос хөлтэй бодит хүний хувьд рационал байдал нь түүнд мөн чанарлаг шинжтэй харин хоёр хөлтэй байдал нь тохиолдлын шинжтэй эсвэл үүний урвуугаар байх тийм бодит хүний тухай ярих нь утгагүй хэрэг болно. Аристотелийн хувьд юмс мөн чанартай байдаг ч лингвистик хэлбэрүүд л утгатай байдаг. Заагдаж буй объектоос салж үгтэй гэрлэх үедээ мөн чанар нь утга болдог.

Утгын онолын тухайд гэвэл хамгийн анхаарал татсан асуулт нь ‘утга гэж ямар төрлийн зүйл вэ?’ хэмээх тухайн онолын объектуудын уг чанарт хандсан асуулт мөн. Утга бол ямар нэг байдлаар санаанд хамаатай гэдэг нь тодорхой байдаг —семантикчдын хувьд оюуны санаанууд, бусдынх нь хувьд бол Платоны санаанууд. Хоёр төрлийн объектын аль аль нь барьцгүй. Энэ нь

үүнийг маргаантай гэсэн үг биш, харин эдгээрийн талаарх үр шимтэй шинжлэх ухааныг босгох найдлага тун бага гэдгийг л хэлж байгаа юм. Өгөгдсөн утгууд хүртэл, хэзээ хоёр утгатай, хэзээ нэг утгатай вэ гэдэг хүртэл тодорхой биш; лингвистик хэлбэрүүдийг хэзээ ойролцоо утгатай, эсвэл утгынхаа хувьд төсөөтэй гэж үзэх, бас хэзээ тэгж үзэхгүй байх нь тодорхой биш. Хэрэв ойролцоо утгын жишгийг тогтооно гэвэл, утгыг нэгж юм гэж үзэх хандлага энэхүү үйл хэрэгт тийм чухал үүрэгтэй оролцохгүй гэж хүлээх үндэслэл бий.

Энд хэлсэн тэр нэгж юмс хэрэгтэй гэж санагдах явдал утга, заагч чанар хоёр тусдаа гэдгийг үнэлэх түрүү үеийн бүтэлгүйтлээс урган гарсан байж болох. Утгын талаарх онолыг заагч чанарын тухай онолоос эрс зааглачихсан бол утгын тухай онолыг лингвистик хэлбэрүүдийн ойролцоо утга хийгээд бодомжуудын аналитик чанарыг л авч үздэг хэмээн зөвшөөрөхөд жижигхэн алхам л хэрэгтэй; утгуудыг өөрсдийг нь завсрын бүрхэг нэгж юмс болохынх нь хувьд орхиж болох юм.

Аналитик чанарыг утгынхаа хувьд үнэн байх явдал гэх дүрслэл нь биднийг утга хэмээх ойлголтын эрэлд гаргасан. Харин бид одоо утга хэмээх нэгж юмсын өвөрмөц аймгийн талаарх бодлыг орхиж байна. Иймд аналитик чанарын талаарх асуудал бидний өмнө шинээр гарч ирж байна.

Философийн ерөнхийлөн баталж хэлдгээр бол аналитик бодомжуудыг бид холоос хайх хэрэггүй. Ийм бодомжууд хоёр ангид хамаардаг. Логикийн хувьд үнэн хэмээн дуудаж болох эхний ангид хамаарах бодомжуудыг дараах жишээнүүдээр тодорхойлж болно:

(1) Нэг ч гэрлээгүй эр бол гэрлэсэн биш. (No unmarried man is married).

Энэ жишээнд хамаарах нэг шинж бол одоо байгаа байдлаараа үнэн байгаад зогсохгүй, ‘хүн,’ ‘гэрлээгүй’ гэх үгсийг өөр ямар ч байдлаар дахин тайлж уншсан бай үнэн хэвээр үлддэг явдал мөн. Хэрэв бид логик эгэл хэсгүүдийн анхдагч нөөцийг ‘үгүй’ (no), ‘үл’ (un), ‘биш’ (not), ‘хэрэв’ (if), ‘тэгвэл’ (then), ‘ба’ (and) зэргээс бүрдэнэ хэмээн үзвэл, ерөнхийдөө логик үнэн гэдэг нь логик хэсгүүдээс нь бусад бүрдлийнх нь алийг ч ямар ч байдлаар дахин тайлж ойлгосон бай үнэн хэвээр үлддэг тийм бодомжууд болж таарна.

Гэхдээ дараах жишээгээр илрэх хоёр дахь анги бүхий аналитик бодомжууд бий:

(2) Нэг ч бакалавр бол гэрлэсэн биш (No bachelor is married)¹⁵².

Ийм бодомж бол нэг үгийг ойролцоо утгатай үгээр нь солих замаар логик үнэн болж хувирдгаараа онцлог; иймд ‘гоонь эр’ гэдгийн оронд ‘гэрлээгүй эр’ гэх ойролцоо утгатай үгийг нь тавьснаар (2)-ыг (1) болгон хувиргах боломжтой. Бид өнөө ч аналитик бодомжийн энэхүү хоёр дахь ангийг оновчтой тодорхойлж чадаагүй байна. Тийм болохоор бас аналитик чанар гэдгийг ерөнхийд нь оновчтой тодорхойлж чадаагүй. Түүнчлэн дээрх дүрслэлд “ойролцоо утга” хэмээх ухагдахуунд хэдий чинээ түшнэ түүнээс дутахааргүй хэмжээнд аналитик чанар гэдгийг өөрийг нь тодруулах хэрэгтэй байна.

Ойрын жилүүдэд Карнап аналитик чанар гэдгийг төлөвийн-дүрслэл (state-descriptions) хэмээн нэрлэсэн зүйлдээ тулгуурлаж тайлбарлах хандлагатай болов.¹⁵³ Төлөвийн-дүрслэл гэдэг бол хэлэнд байх дурын атомон буюу үл хуваагдах бодомжид үнэний утгыг шавхан хамаатуулах явдал мөн. Хэлэнд байх бусад бүх бодомж бол бүрдэл болж буй гишүүн өгүүлбэрүүд дээр нь мөнөөх логик хэрэгслүүдийг ашиглах замаар ямар ч нийлмэл бодомжийн үнэний утга нь өвөрмөц логик хуулиар төлөвийн-дүрслэл бүрд төвшитгөгдсөн байх тийм хэлбэрээр тогтсон байна хэмээн Карнап үзжээ. Тэгснээр бодомжийг бүх төлөвийн-дүрслэл дор үнэн болж байгаа

¹⁵² Орчуулагчийн тэмдэглэл: Англи хэлний “bachelor” гэх үг эрдмийн зэргээс гадна гоонь эр гэх утгыг илэрхийлдэг. Энд гарч буй “бакалавр” хэмээх үгийг гоонь эр гэх утгаар нь ойлгоно уу.

¹⁵³ R. Carnap, *Meaning and Necessity* (Chicago, 1947), pp. 9ff.; *Logical Foundations of Probability* (Chicago, 1950), pp. 70ff.

үедээ аналитик байна хэмээн тайлбарласан байна. Энэ баримтлал бол Лейбницийн “бүх боломжит ертөнцөд үнэн” гэдгийг шинэчилсэн хувилбар юм. Гэхдээ аналитик чанарын энэ хувилбар нь хэлэнд буй атомон бодомжууд, ‘Жон бол гоонь’ бас ‘Жон гэрлэсэн’ гэдгээс ялгаатайгаар, харилцан тусгаар байх үед л зорилгодоо үйлчилнэ гэдгийг онцлох хэрэгтэй. Үгүй бол ‘Жон бол гоонь’ гэдэгт үнэнийг хамаатуулаад, ‘Жон гэрлээгүй’ гэдэгт худлыг хамаатуулах төлөвийн-дүрслэл байх байсан, тэгснээр ‘Бүх бакалавр гэрлэсэн биш’ гэдэг нь дээрх шалгуурын үүднээс аналитик биш синтетик болж таарна. Иймд төлөвийн-дүрслэлд тулгуурласан аналитик чанарын шалгуур нь ‘гоонь’ болон ‘гэрлээгүй эр’ гэдэг шиг логигоос гадна байх ойролцоо үгсийн хослол (ийм хослолууд аналитик бодомжийн “хоёрдугаар анги”-ийг бүрдүүлдэг) байдаггүй тийм хэлэнд л үйлчилнэ. Төлөвийн-дүрслэлд тулгуурласан шалгуур нь логик үнэн гэдгийг сэлбэн зассан хувилбараас хэтрэхгүй.

Би энэ тухайд Карнапыг хий юм харсан гэж хэлэх гэсэнгүй. Түүний хялбаршуулсан загвар бүхий хэл нь, бас төлөвийн-дүрслэлүүд нь аналитик чанарын ерөнхий асуудлаас өөр зорилгод буюу индукц хийгээд магадлалыг тодруулахад чиглэсэн байв. Бид харин аналитик чанарын тухай асуудлыг авч үзэж байгаа; бас уг асуудлын гол зангилаа аналитик бодомжуудын эхний анги буюу логик үнэнд биш харин ойролцоо утгын тухай ухагдахуунаас хамаарах хоёрдугаар ангид бий.

II. ТОДОРХОЙЛОЛТ

Хоёрдугаар ангид хамаарах аналитик бодомжууд нь нэгдүгээр анги буюу логик үнэн гэдэгт тодорхойлолтынхоо хувьд дүйнэ гэж үзсэнээр асуудлыг намжаана гэж боддог хүмүүс бий; жишээ нь, ‘бакалавр’ гэдгийг ‘гэрлээгүй эр’ гэж тодорхойдог. Гэхдээ ‘Бакалавр’ гэдгийг ‘гэрлээгүй эр’ гэж тодорхойлж болох эсэхийг бид яаж мэдэх вэ? Хэн, хэзээ ингэж тодорхойлсон юм бэ? Хамгийн ойр байгаа толио барьж аваад, толь зүйчийн томъёоллыг хууль хэмээн хүлээн авах учиртай юу? Энэ нь тэргээ мориныхоо урд бэхэлснээс өөрцгүй хэрэг болох нь гарцаагүй. Толь зүйч бол түрүү үеэсээ бичигдэж ирсэн баримтуудтай ажилладаг эмпирик шинжлэх ухаанч мөн; тэр ‘бакалавр’ гэдгийг ‘гэрлээгүй эр’ хэмээн тайлбарласан байвал, түүнийг толио бичихээс өмнө ерөнхий эсвэл илүү ноёлсон хэрэглээнд, дээрх хэлбэрүүдийн хооронд ойролцоо утгын харилцаа байна хэмээн үнэмшсэн учир л тийн бичсэн хэрэг. Энд утгуул санаа болж буй ойролцоо утгын тухай ухагдахууныг бас л тодруулах хэрэгтэй байна. Миний харж байгаагаар лингвистик авир үйлтэй холбоотой нэр томъёонуудын үүднээс тодруулах хэрэгтэй бололтой. Толь зүйчийн ойролцоо утга хэмээн ажиглаад “тодорхойлолт” хэмээсэн зүйлийг ойролцоо утгын суурь хэмээн хүлээн авч болохгүй нь мэдээж.

Тодорхойлолтыг дан ганц хэл бичиг судлаач (philologist) нар хийдэггүй. Философичид болон шинжлэх ухааныхан ч ойлгоход бэрх нэр томъёог ойлгоход илүү дөхүү үгсийн санд тулгуурласан нэр томъёонуудыг ашиглан ‘тодорхойлох’ нь олон. Гэвч жирийн үед бол, хэл бичиг судлаачдынх шиг тодорхойлолтууд бол өөрсдөд нь буй тэр тайлбараас түрүүнд байсан тийм ойролцоо утгын харилцаа байгааг хүлээн зөвшөөрсөн, цэвэр толь зүйн шинжтэй байдаг.

Ойролцоо утгыг зөвшөөрнө гэдэг нь юу гэсэн үг болох, хоёр лингвистик хэлбэрийг ойролцоо утгатай хэмээн зохих ёсоор дүрслэхэд зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй харилцан холбоо нь юу байж болох вэ гэдэг нь тодорхой болсон гэж хэлтэл бид өдий байна; гэвч энэ харилцан холбоо нь юу ч байлаа гэсэн, жирийн үед бол хэрэглээнд тулгуурласан байна. Тэгвэл ойролцоо утгын сонгогдсон жишээнүүдийн талаар мэдээлж буй тодорхойлолтууд бол хэрэглээний талаарх мэдээлэл болж ирнэ.

Гэхдээ урьдаас оршиж байсан ойролцоо утгат үгсийн талаар мэдээлэх явдлаар хязгаарлагддаггүй тийм тодорхойлолтын үйл ажиллагаа бас бий. Үүгээр би Карнапын дэлгэрүүлэл (explication) хэмээн нэрлэсэн философичдын гүйцэтгэдэг, бас шинжлэх ухаанчид философид илүү ойртсон үедээ хийдэг тэр үйл ажиллагааг хэлж байна. Дэлгэрүүлэл нь

тодорхойлогдогчийг (definiendum) шууд ойролцоо утгатай үгээр нь илэрхийлэх төдийгүй тухайн тодорхойлогдогчийн утгыг сайжруулж эсвэл нөхөх замаар хөгжүүлэхэд чиглэсэн байна. Гэвч дэлгэрүүлэл хүртэл, зүгээр л тодорхойлогдогч болон тодорхойлогчийн (definiens) хооронд урьдаас оршиж байсан ойролцоо утгыг мэдээлэх төдийгөөр хязгаарлагддаггүй ч гэлээ, урьдаас оршиж байсан бусад өөр бусад ойролцоо утгат үгст ямар нэг байдлаар тулгуурлаж таардаг. Энэ асуудлыг дараах байдлаар үзэж болох юм. Дэлгэрүүлэл хийхэд зохих ямар ч үг тодорхой хам сэдэв байдаг бөгөөд, тэр нь бүхлээрээ бол хэрэгцээтэй байхад хангалттай түвшинд нарийн, тодорхой байдаг; бас дэлгэрүүлэл хийхийн зорилго нь ийм хам сэдвүүдийн хэрэглээг хадгалж үлдэхийн хажуугаар өөр бусад хам сэдвийн хэрэглээг тодруулахад чиглэнэ. Тэгэхээр аливаа тодорхойлолт нь дэлгэрүүллийн зорилгод нийцсэн байхын тулд тодорхойлогдогч нь урьдын хэрэглээнд тодорхойлогчтой ойролцоо утгатай байх биш харин тодорхойлогдогчийн мөнөөх хам сэдэв нь урьдын хэрэглээндээ, тодорхойлогчийн харгалзах хам сэдэвтэй ойролцоо утгатай байх шаардлагатай. Аливаа дэлгэрүүлэл хийх зорилгод хоёр өөр тодорхойлогчийн аль аль нь зохиж байж болох ч нэг нэгтэйгээ ойролцоо утгагүй байж болно; учир нь давуу байгаа мөнөөх хам сэдвүүдийн дотор бол тэдгээр тодорхойлогчдыг өөр хооронд нь сольж хэрэглэх боломжтой байхад өөр хам сэдвүүдийн хүрээнд бол салаа утгатай байж болно. Уг тодорхойлогчдын нэг биш нөгөөд нь ойр байснаар дэлгэрүүлэгч төрлийн тодорхойлолт тодорхойлогдогч болон тодорхойлогчийн хооронд өмнө байгаагүй ойролцоо утгын харилцааг батламжлалаар бий болгодог. Гэлээ ч тэр тодорхойлолт нь, өмнө дурдсанчлан, дэлгэрүүлэх үүргээ урьдаар-оршиж байсан ойролцоо утгад тулгуурлаж гүйцэтгэдэг.

Ингээд ч болоогүй, түрүүнд байсан ойролцоо утга руу ердөөс эргэдэггүй тийм эрс төрлийн тодорхойлолт бас бий; тухайлбал, ердөө товчлох зорилгоор шинэ тэмдэглэгээнүүдийг илэрхий уламжлалт байдлаар танилцуулдаг. Энд тодорхойлогдогч нь тодорхойлогчтой ойролцоо утгыг илтгэх зорилгын үүднээс би болсон учраас л тодорхойлогчтой ойролцоо утгатай болж байна. Үүнээс тодорхойлолтоор бий болсон ойролцоо утгын маш тунгалаг тохиолдлыг харж болно; ойролцоо утгын энэ төрөл зүйлүүд бүгд ойлгомжтой байсан болоосой. Үлдсэнийх нь хувьд тодорхойлолт нь тайлбар хийхээс илүү ойролцоо утга дээр тулгуурлаж байгаа. Логик, математикийн сүүл үеийн бичвэрүүдэд ‘тодорхойлолт’ хэмээх үгийг баттай хэмээн тун аюултайгаар хэрэглэх тохиолдол олон гарах болсон нь эргэлзээгүй. Одоо формал бүтээлүүдэд тодорхойлолт ямар үүрэгтэй оролцдог талаарх сэдэв рүү хальж орё.

Логикийн бас математикийн тогтолцоонд антагонист байдлаараа хоорондоо ижил хоёр хэв шинжийн эдийн засгийн аль аль нь нэг рүү нь илүү тэмүүлдэг хандлага бий. Бас тэд хоёул өвөрмөц практик үр ашгийг авчирдаг. Нэг талаас бид практик илэрхийллийн эдийн засгийг эрж болно: олон төрлийн харилцааны бодомжуудын товч бөгөөд хялбар байдал. Ийм төрлийн эдийн засаг ихэвчлэн ойлголтуудын баялагт зориулсан нарийн тодорхой бөгөөд ялгац бүхий тэмдэглэгээнүүдийг шаарддаг. Харин хоёрдахь тохиолдолд эсрэгээрээ, дүрэм болон үгсийн сангаас эдийн засгийг эрнэ; суурь ойлголт (basic concept) тус бүрд ялгац бүхий тэмдэглэгээг тааруулсан нөхцөлд суурь тэмдэглэгээнүүдийнхээ хослол болон давталтаар хүссэн нэмэлт ойлголтоо илэрхийлэх боломж бүрдэхүйц тийм байдлаар хамгийн бага суурь ойлголтуудыг олохоор оролдож болно. Энэ хоёрдогч төрлийн эдийн засаг нь нэг талаар практик биш шинжтэй. Учир нь суурь хэлцүүдээр ядмаг байх явдал нь дискурсыг сунгах хандлагатай байдаг. Гэхдээ нөгөө нэг талаар бол практик шинжтэй. Энэ нь хэлийг бүрдүүлж буй нэр томъёо хийгээд бүтцийн хэлбэрүүдийг багасгаснаар хэлний талаарх онолын дискурсыг үлэмж хэмжээнд хялбаршуулдаг.

Хоёр төрлийн эдийн засгийн аль аль нь, эхлээд харах юм бол, өөр өөрийн гэсэн үнэ цэнтэй. Үүнтэй холбоотойгоор бид нэг нь нөгөөгийнхөө хэсэг нь болдог хоёр өөр хэл бүтээх замаар дээрх хоёр төрлийн эдийн засгийг хослуулж хэвшив. Илүү өргөн хэмжээтэй хэл нь дүрэм

хийгээд үгсээр элбэг дүүрэн ч мессежний уртыг хэмнэдэг. Харин примитив тэмдэглэгээ гэгдэх нөгөө нэг нь дүрэм хийгээд үгст ариг гамтай байна. Бүхэл ба хэсэг нь орчуулгын дүрмүүдээр харилцан хамааралд байдаг. Үүний ачаар примитив тэмдэглэгээнд үл байх хэлц тус бүр примитив тэмдэглэгээний ямар нэг нийлмэл цогцтой тэнцэтгэгдэнэ. Орчуулгын энэ дүрмүүд бол формал тогтолцоонуудад тодорхойлолт гэгддэг тэр зүйлс мөн. Эдгээрийг нэг хэлний нэмэлт биш харин нэг нь нөгөөгийнхөө хэсэг нь байх хоёр өөр хэлний хооронд буй харилцан хамаарал гэж харвал хамгаас зохилтой.

Гэхдээ энэ харилцан хамаарал нь санамсаргүй шинжтэй зүйл биш. Энэ нь товч бөгөөд эвтэй байдлыг хадгалах, хэлийг баялаг байлгах гээд мөнөөх бүх зорилгуудыг примитив тэмдэглэгээнүүд хэрхэн биелүүлдгийг харуулах учиртай. Учир нь тодорхойлогдогч хийгээд түүний тодорхойлогчийг, тохиолдол бүрд, түрүүн цохсон гурван арга замын аль нэгээр хоорондоо холбогдсон байна хэмээн үзэж болно. Тодорхойлогдогчийг илүү нарийн тэмдэглэгээгээр илэрхийлж байгаа гэдэгт итгэж болохоор, өмнө байсан хэрэглээнээс эхлээд шууд ойролцоо утгыг хадгалах тийм байдлаар тодорхойлогдогчийг өөрчилсөн үгс нь тодорхойлогч байж болно; эсвэл тодорхойлогч гэдэг нь, дэлгэрүүллийн амин сүнс дотор, тодорхойлогдогчийн өмнө байсан хэрэглээн дээр хөгжиж гарсан байж болно; эсвэл, эцсийн нэг хувилбар нь, тодорхойлогдогч бол шинээр бий болсон тэмдэглэгээ бөгөөд дөнгөж саяхан утга олсон байж болно.

Тэгэхээр бид формал болон формал биш аль ч ажлаас тодорхойлолт нь —шинэ тэмдэглэгээг илэрхий уламжлалт байдлаар танилцуулах эрс тохиолдлоос бусад нөхцөлд— түрүүнд байсан ойролцоо утгын харилцаанаас хамаарч байдгийг мэдэх учиртай. Тэгвэл тодорхойлолт хэмээх ухагдахуунд ойролцоо утга бас аналитик чанарын түлхүүр байхгүйг зөвшөөрөөд, тодорхойлолтын тухайд дахин авч үзэлгүй ойролцоо утгын тухайд лавшруулан үзье.

III. ХАРИЛЦАН ОРЛУУЛАГДАХ БАЙДАЛ

Нарийн шалгаж үзвэл зохих ердийн болсон нэг санал байдаг нь хоёр лингвистик хэлбэрийн дундах ойролцоо утга нь тэр хоёрын нэгийг нөгөөгөөр нь орлуулахад бүх хам сэдэв дотор үнэний утга нь өөрчлөгддөггүй байдалд оршдог гэх санаа юм; харилцан орлуулагдах байдал гэдгийг Лейбницийнхээр *salva veritate* гэнэ. Ойролцоо утга гэдгийг тийн ухаж ойлговол, ойролцоо утгатай үгс бүрхэг, ойлгомжгүй утгатай биш байх ч шаардлагагүй бөгөөд утгын бүрхэг ойлгомжгүй байдал нь хоорондоо таарч байхад л болно.

Гэтэл ‘бакалавр’ болон ‘гэрлээгүй эр’ гэх ойролцоо утгатай үгсийг бүх нөхцөлд *salva veritate* байдлаар харилцан орлуулагддаг гэхэд хэцүү. ‘Гэрлээгүй эр’ гэдгийг ‘бакалавр’ гэдгээр орлуулахад худал болох тийм үнэнүүдийг ‘урлагийн бакалавр’ эсвэл ‘бакалаврын товч’ (холтсон цэцгийг англи хэлэнд ‘bachelors button’ гэж хэлдэг) гэх үгсийг ашиглаад хялбархан гаргаад ирж болно. Хашилт ашиглах замаар ч бас тэгж болно, тэгвэл:

‘Бакалавр’ гэхэд арваас цөөн үсэг ордог.

Гэхдээ, ‘урлагийн бакалавр,’ ‘бакалаврын товч’ гэх мэт үгс бас “бакалавр” гэх хашилттай үгийг тус бүрд нь дахин хуваагдашгүй үгс хэмээн үзээд, *salva veritate* байдлаар харилцан орлуулагдах явдал буюу ойролцоо утгат үгсийн шалгуур нь үгэн дотор буй тасархай хэсгүүдэд хамаарахгүй гэх болзол оруулснаар дээрх шиг сөргүүлсэн тохиолдлуудыг аргалж болно. Ойролцоо утгат үгсийн талаарх энэ баримтлалыг өөр бусад талаар нь хүлээн зөвшөөрлөө ч гэсэн, “үг” гэдгийн талаарх урьдач шинжтэй, томъёолол дунд хэд хэдэн асуудал үүсгэж буй ойлгоцод ханддаг учраас дутагдалтай гэдэг нь үнэн. Юутай ч ойролцоо утгын тухай асуудлыг үгшлийн (wordhood) асуудал болгож цомхотгосон нь тодорхой дэвшил авчирсан хэмээж болох юм. “Үг” гэдгийг асуудалгүй хэмээн үзээд, дээрх асуудлыг цааш хөөж үзье.

Salva veritate харилцан орлуулагдах байдал (үгс доторх тохиолдлуудаас үл хамааран) ойролцоо утгын хангалттай хүчирхэг нөхцөл мөн эсэх тухай асуудал, эсвэл эсрэгээрээ, ойролцоо утгатай биш аливаа илэрхийллүүдийг хооронд нь тэгж харилцан орлуулж болдог эсэх тухай асуудал шийдэгдээгүй хэвээр байна. Энд ойролцоо утга гэдгийг сэтгэл зүйн холбоос эсвэл яруу найргийн чанарын хувьд бүрэн адилсал гэх утгаар авч үзэхгүй байгаагаа тодруулж хэлье; ямар ч хоёр өөр илэрхийлэл тийм үүднээс ойролцоо утгатай байхгүй. Харин энд танин мэдэхүйн ойролцоо утга гэж болох тэр зүйлд л анхаарлаа хандуулж байгаа. Одоо хийж буй судалгаагаа гүйцээлгүйгээр үүнийг юу вэ гэдгийг хэлж дөнгөхгүй; гэхдээ нэгдүгээр хэсэгт үүний аналитик чанартай холбогдох тэр талаас үүдэн бий болсон хэрэгцээнээс үүний талаар нэг зүйл мэдэж авсан. Тэнд бидэнд нэг үгийг ойролцоо утгатай үгээр нь сольж аналитик бодомжийг логик үнэн болгох тийм төрлийн ойролцоо утга хэрэгтэй болсон. Нөхцөл байдлыг орвонгоор нь эргүүлж, аналитик чанарыг авч үзвэл, бид нэр томъёонуудын танин мэдэхүйн ойролцоо утгыг дараах байдлаар тайлбарлаж болох нь үнэн (мөнөөх жишээгээ татъя): ‘бакалавр’ болон ‘гэрлээгүй эр’ хоёрыг танин мэдэхүйн хувьд ойролцоо утгатай хэмээх нь дараах бодомжоос илүүг ч, дутууг ч хэлээгүй хэрэг мөн:

(3) Бүх бакалавр, бас зөвхөн бакалаврууд бол гэрлээгүй гэдэг нь аналитик шинжтэй.¹⁵⁴

Бидэнд танин мэдэхүйн ойролцоо утгын талаарх, аналитик чанарыг угтуул санаагаа болгоогүй (presuppose) тийм баримтлал л хэрэгтэй —эсрэгээрээ, нэгдүгээр хэсэгт үзсэн шигээр танин мэдэхүйн ойролцоо утгын тусламжтайгаар аналитик чанарыг тайлбарлах гэвэл, бас ойролцоо утгын талаарх тийм бие даасан баримтлалыг, өөрөөр хэлбэл үгс дотор байхаас бусад бүх тохиолдол дахь *salva veritate* харилцан орлуулагдах байдлыг авч үзэж байгаа нь үнэн. Сүүлд ярьж байсан зүйлээ үргэлжлүүлэхэд, бидний өмнө буй асуулт бол тийм харилцан орлуулагдах байдал нь танин мэдэхүйн ойролцоо утгын хүрэлцээтэй нөхцөл мөн эсэх тухай юм. Бид дараах төрлийн жишээнүүдээр өөрсдийгөө тайвшруулж болно.

(4) Бүх бакалаврууд, бас зөвхөн бакалаврууд бол гэрлээгүй эрс гэдэг нь зайлшгүй

гэх бодомж үнэн. ‘Зайлшгүй’ гэдгийг зөвхөн аналитик бодомжуудад л үнэнээр хамаатдаг гэдгийг тун нарийн байдлаар ойлгож хүлээн авсан ч үнэн хэвээр байна. Тэгэхээр, ‘бакалавр’ болон ‘гэрлээгүй эр’ гэдэг нь *salva veritate* байдлаар харилцан орлуулагддаг юм бол (4)-дээр гарч буй ‘бакалавр’ гэдгийн оронд ‘гэрлээгүй эр’ гэж тавьсны үр дүн нь (4)-тэй адил үнэн байх ёстой.

(5) Бүх бакалаврууд, бас зөвхөн бакалаврууд гэрлээгүй гэдэг нь зайлшгүй

Гэтэл (5)-ыг үнэн гэж хэлэх нь ‘бакалавр’, ‘гэрлээгүй эр’ хоёр танин мэдэхүйн хувьд ойролцоо утгатай учраас (3) нь аналитик юм гэж хэлж буй хэрэг болно.

Дээрх үндэслэгээний юу нь үүнд илбэ хийх боломж олгож байгаа талаар үзье. *Salva veritate* байдлаар харилцан орлуулагдах нөхцөл нь хэрэглэж буй хэлний баялаг байдлаас хамаараад хүчнийхээ хувьд ялгаатай байна. Дээрх үндэслэгээ биднийг зөвхөн аналитик бодомжууд дээр л үнэн байна гэж ойлгох ‘зайлшгүй’ гэх дайвар үгийг агуулахад хангалттай баялаг хэлэн дээр ажиллаж байна хэмээн үзсэн байна. Гэхдээ тийм дайвар үг агуулсан хэлийг зөвшөөрч болох уу? Энэ дайвар үг үнэхээр ойлгомжтой байна гэж үү? Үүнийг ойлгомжтой байна гэж үзэх нь өөрөө биднийг хэдий нь ‘аналитик’ гэдгийн сэтгэлд хүрэхүйц утгат чанарыг гаргачихсан гэж үзэж буй хэрэг мөн. Тэгвэл бид чинь юуны төлөө ингэж их чармайлт гаргаад байгаа билээ?

¹⁵⁴ Энд танин мэдэхүйн ойролцоо утга гэдгийг анхдагч, өргөн утгаар нь хэрэглэж байгаа. Carnap (*Meaning and Necessity*, pp. 56ff.), Lewis (*Analysis of Knowledge and Valuation* [La Salle, Ill., 1946], pp. 83ff.) нар танин мэдэхүйн ойролцоо утга гэдгийн зарим нөхцөлд илүү хэрэгтэй, явцуу утгыг гарган авч болох талаар санал дэвшүүлсэн бий. Гэхдээ ойлголтыг салаалуулж байгуулах энэ өвөрмөц ажил нь авч үзэж буй асуудалд маань хамаагүй. Мөн үүнийг энд ашиглаж буй танин мэдэхүйн ойролцоо утгын талаарх өргөн утгатай хольж болохгүй.

Үндэслэгээ маань илт тойрч буцсан шинжтэй биш ч гэлээ үүнд дөхнө. Дүрслэлж яривал энэ маань огторгуй дахь битүү муруй хэлбэртэй.

Salva veritate харилцан орлуулагдах байдал нь холбогдох талуудаараа хүрээ нь тодорхой болсон хэлэнд харьцангуйлагдаж орохоос нааш утгагүй байна. Дараа дурдах материалуудыг агуулсан хэлний тухай авч үзэж байна гээд үзье. Нэг —бас олон— байрт предикатуудын хязгааргүй их нөөц бий. Тэдгээрээс ихэнх нь логигоос гадна байх сэдэвт хамааралтай. Хэлний үлдсэн хэсэг нь логикийнх байна. Атоман өгүүлбэрүүд нэг эсвэл түүнээс олон хувьсагч дагуулсан предикатаас бүрдэнэ; харин нийлмэл өгүүлбэрүүд үнэний функц болон квантичлалын тусламжтайгаар нийлсэн атоман өгүүлбэрүүдээс бүрдэнэ. Дүрслэлүүд, анги бүлэг юмсын нэр ганц тоон дээрх нэрсийг бид өөрсдийн мэдэх арга замаар хам сэдвээр нь тодорхойлох боломжтой гэж үзвэл, үр дүнд нь тус хэл дээрх зүйлсийн ач тусыг нийтдээ хүртэнэ.¹⁵⁵ Хэрэв шинжлэх ухаан гэдэгт модаль дайвар үг, баримттай-зөрөлдсөн болзолт өгүүлбэр гэх мэт маргаан дагуулсан хэрэгслүүдийг хамаатуулж үзээгүй бол тус хэл сонгодог математикт, бас шинжлэх ухааны дискурст нийтэд нь зохимжтой байна. Ийм хэв шинжид хамаарах хэл энэ үүднээс бол багтаамжийн шинжтэй (extensional) байна: багтаамжийн хувьд таарч буй (ижид объектод үнэн байх) дурын хоёр предикат *salva veritate* байдлаар харилцан орлуулагдана.

Тэгэхээр, багтаамжийн хэлэнд бол *salva veritate* харилцан орлуулагдах байдал нь бидний хүсэж байгаа шиг танин мэдэхүйн ойролцоо утгын баталгаа биш. ‘Бакалавр’ болон ‘гэрлээгүй эр’ хоёр багтаамжийн хэлэнд *salva veritate* харилцан орлуулагддаг нь (3) бол үнэн гэдгээс өөр зүйлийг бидэнд баталж чадахгүй. ‘Зүрхтэй амьтан’ болон ‘бөөртэй амьтан’ хоёрын багтаамжийн нийцэлтэй адилаар, ‘бакалавр’, ‘гэрлээгүй эр’ хоёрын багтаамжийн нийцлийг тохиолдлын шинжтэй үйл явдал биш харин утга дээр тулгуурласан гэдгийг батлах зүйл үгүй.

Багтаамжийн нийцэл нь дийлэнх зорилгын хүрээнд бидний анхаарч үзэх хэрэгтэй тэр ойролцоо утгад хамгийн дөхүү зүйл мөн. Гэхдээ багтаамжийн нийцэл нь аналитик чанарыг нэгдүгээр хэсэгт гарсан тэр байдлаар тайлбарлахад шаардлагатай хэв шинж бүхий танин мэдэхүйн ойролцоо утга байж дөнгөхгүй. Үүнд шаардлагатай хэв шинжийн танин мэдэхүйн ойролцоо утга нь ‘бакалавр’, ‘гэрлээгүй эр’ хоёрыг (3)-ын үнэн төдийгөөр биш харин (3)-ын аналитик чанараар тэнцэтгэх ёстой.

Тэгэхээр бид *salva veritate* харилцан орлуулагдах байдлыг багтаамжийн хэлтэй холбоотойгоор ойлгож байгаа бол энэ нь нэгдүгээр хэсэгт гарсан тэр байдлаар аналитик чанарыг гарган авахад хэрэгтэй тэрхүү танин мэдэхүйн ойролцоо утгад хүрэлцээтэй нөхцөл болохгүй гэдгийг ухаарах учиртай. Хэрэв аливаа хэл түрүүн тэмдэглэдэг тэр үүднээс ‘зайлшгүй’ гэх интенционал дайвар үгийг, эсвэл түүнтэй төстэй нөлөө бүхий өөр эгэл хэсгийг агуулж байгаа бол, тийм хэлэнд буй *salva veritate* харилцан орлуулагдах байдал нь танин мэдэхүйн ойролцоо утгын хүрэлцээтэй нөхцөлийг биелүүлж хүчирнэ; гэхдээ аналитик чанарын талаарх ухагдахууныг урьдаар тодорхой ойлгосон үед л тийм хэл ухварлагдахууц (intelligible) байна.

Сүүлд нь нэгдүгээр хэсэгт байсан шиг аналитик чанарыг гарган авахын тулд эхлээд танин мэдэхүйн ойролцоо утгыг ойлгох гэж хүчин чармайлт гаргах нь буруу арга барил байж мэдэх юм. Оронд нь танин мэдэхүйн ойролцоо утгад хандалгүйгээр аналитик чанарыг тайлбарлах гээд оролдож болох юм. Харин тэгснийхээ хойно, бидэнд хэрэгтэй бол аналитик чанараас танин мэдэхүйн ойролцоо утгыг шаардлага хангасан байдлаар гаргаад ирж болох нь эргэлзээгүй. ‘Бакалавр’, ‘гэрлээгүй эр’ хоёрын дундах танин мэдэхүйн ойролцоо утгыг (3)-ын аналитик чанар болгон тайлбарлаж болохыг бид үзсэн. Үүнтэй ижил тайлбар ямар ч нэг байрт (one-place) предикатуудын хослолд хүчинтэй. Бас үүнийг өргөжүүлэн олон байрт (many-place) предикатууд

¹⁵⁵ Миний бичсэн *Mathematical Logic* (New York, 1940; Cambridge, Mass., 1947), sec. 24, 26, 27; эсвэл *Methods of Logic* (New York, 1950), sec. 37ff-ыг үзнэ үү.

дээр хэрэглэж болох нь мэдээж. Өгүүлбэр зүйн бусад категориудыг бас параллель хэлбэрээр дажгүй байр сууринд тавьчихаж болно.

Ганц тоон дээр буй нэр томъёонуудын дунд '=' тавьснаар үүсэх адилслын бодомж нь аналитик байх юм бол тэдгээрийг танин мэдэхүйн хувьд ойролцоо утгатай гэж болно. Хоёр бодомжийн эквиваленци нь ('зөвхөн . . . бол . . . ' гэдгээр холбоод гарах өгүүлбэр) аналитик байх юм бол тухайн бодомжуудыг танин мэдэхүйн хувьд ойролцоо утгатай гээд зүгээр л хэлчхэж болно.¹⁵⁶ Хэрэв бүх категорийг нэг томъёололд бөөгнүүлэхэд анхаарал тавья гэвэл, энэ хэсгийн эхэнд хэрэглэсэн "үг" гэх ухагдахууныг дахин авч үзэн байж, хоёр лингвистик хэлбэр нь *salva* (*veritate* байхаа болиод) *analyticitate* байдлаар харилцан орлуулагдаж ("үгс" доторх тохиолдлуудаас үл хамааран) болж байгаа үед дурын хоёр лингвистик хэлбэрийг танин мэдэхүйн хувьд ойролцоо утгатай хэмээн дүрсэлж болно. Хоёрдмол байдал эсвэл ижил нэрийн тохиолдлууд дээр тодорхой техник асуудлууд гарч ирэх нь үнэн; бид хэдий нь ухарч буцаж байгаа ч гэлээ тэр асуудлууд дээр саатахгүй байя. Харин ойролцоо утгын талаарх асуудлыг хойноо орхиод, аналитик чанарын талаарх шинэ асуудлыг авч үзье.

IV. УТГА ЗҮЙН ДҮРМҮҮД

Эхэндээ аналитик чанарыг утгын аймагт хандсанаар тодорхойлох нь хамгийн ердийн мэт байв. Үүнийг сайжруулахад, утгад хандах явдал нь ойролцоо утга эсвэл тодорхойлолтод хандах арга замыг гаргаж өгөв. Гэтэл тодорхойлолт нь төөрөгдлийн дөл (*will-o'-the-wisp*) болж таарсан бол ойролцоо утга хэмээгчийг эхлээд аналитик чанарт өөрт нь хандаж байж л хамгийн зөвөөр ойлгодог болж таарав. Ингээд бид аналитик чанарын асуудал дээр эргээд очлоо.

'Ногоон юм бүхэн орон зайд тэлсэн байдаг' (*everything green is extended*) гэх бодомж аналитик эсэхийг би мэдэхгүй. Харин энэ жишээний тухайд эргэлзсэн байдал маань гүйцэд бус ойлгохуйг буюу 'ногоон' бас 'орон зайд тэлсэн' гэдгийн "утгууд"-ыг гүйцэд бус ойлгосон явдлыг үнэхээр илчилж байна уу? Би тийм гэж бодохгүй байна. Гол асуудал 'ногоон' эсвэл 'орон зайд тэлсэн' гэдэгт биш, харин 'аналитик' гэдэгт байна.

Ердийн хэлэнд, аналитик бодомжуудыг синтетик бодомжуудаас зааглахад гардаг асуудлыг ердийн хэлний бүдэг байдалтай холбоотой гээд, яв цав "утга зүйн (*semantical*) дүрэм" бүхий нарийн тодорхой зохиомол хэл байх юм бол уг зааг илэрхий болно гэх санаа их цухуйдаг. Гэвч энэ нь эндүүрэл гэдгийг би одоо харуулахыг оролдоно.

Бидний санаагаа чилээж буй аналитик чанар хэмээх ухагдахуун бол бодомжууд хийгээд хэлнүүдийн дунд байдаг хэмээн тооцогддог нэг төрлийн харилцаа мөн: *S* бодомж нь *L* хэлэнд аналитик гэгдэх бөгөөд дээрх харилцааг, өөрөөр хэлбэл *S'* болон '*L*' хувьсагчийн хоорондох харилцааг ерөнхийд нь ойлгомжтой болгоход асуудалтай байдаг. Би энэ асуудлын гол хүндрэл зохиомол хэлнүүдэд ердийн хэлэнд байдгаас тийм бага тулгардаг юм биш гэж хэлмээр байна. '*S* нь *L*-д аналитик байна' гэх хэлцийг, '*S'* болон '*L*' хувьсагчтай хамт ойлгомжтой болгоход тулгарч буй асуудал '*L*' хувьсагчийн хүрээг зохиомол хэлнүүдээр хязгаарласан ч хэвээр үлдэнэ. Одоо үүнийг нотлон харуулъя.

Зохиомол хэлнүүд хийгээд утга зүйн дүрмүүдийн тухайд бол бид угаас Карнапын бичвэрүүдэд хандана. Түүний утга зүйн дүрэм хэд хэдэн хэлбэртэй. Би санаагаа дэвшүүлэхийн тулд тэдгээр дүрмүүдийг тодорхой байдлаар ялгах болно. Утга зүйн дүрмүүд нь рекурс эсвэл өөр ямар нэг аргаар *L*-д буй бүх аналитик бодомж тус бүрийг ялгаж илтгэх хэлбэр бүхий *L* гэх зохиомол хэлийг авч үзэхээс эхэлье. Уг дүрмүүд нь зөвхөн тийм, тийм бодомжууд '*L*'-ийн аналитик бодомжууд гэдгийг хэлж өгдөг. Энэ дүрмүүд бидний ойлгохгүй байгаа 'аналитик' гэдэг мөнөөх үгийг агуулж байгаа нь л өөрөө асуудал! Бид дүрмүүд нь ямар илэрхийллүүдэд

¹⁵⁶ 'Зөвхөн . . . бол . . . ' гэдгийг өөрийг нь үнэний функцийн утгаар ойлгосон байдаг. Carnap, *Meaning and Necessity*, p. 14.-ыг үзнэ үү.

аналитик чанарыг хамаатуулж буйг ойлгосон ч, дүрмүүд маань тэрхүү илэрхийллүүдэд чухам юуг хамаатуулж байгааг ойлгохгүй байна. Товчхондоо бол, бид “зөвхөн . . . бол S бодомж нь L_0 -д аналитик байна” гэж эхэлдэг дүрмийг ойлгохоос урьдаар ‘. . .-нд аналитик’ гэх ерөнхийлсөн харьцангуй нэр томъёог ойлгох ёстой; ‘ S ’, ‘ L ’ гэдэг хувьсагчтай үед, ‘ S ’ нь ‘ L ’-д аналитик байна гэж юу гэсэн үг болохыг ойлгох ёстой.

Нөгөөтэйгүүр бид бас дүрэм гэж буй зүйлээ ‘ L_0 -д аналитик’ гэх шинэ тэмдгийн талаарх зөвшилцөл бүхий тодорхойлолт хэмээн үзэж болох нь үнэн. Энэ тэмдгийг ‘ K ’ гээд ‘аналитик’ хэмээх нөгөө сонирхолтой үг дээр анхаарал хандуулахгүй байгаа мэтээр бичихвэл илүү дээр байж мэднэ. L_0 -д багтаж буй K , M , N гэх мэт хэдэн ч бодомжоос бүрдсэн аливаа ангийг, олон төрлийн зорилгын дагуу эсвэл ямар ч зорилгогүйгээр тусгайлан тогтоож болно; M , N зэргээс ялгаатай нь, K бол L_0 -д буй “аналитик” бодомжуудын анги юм гэдэг нь юу гэсэн үг вэ?

L_0 -ын хувьд ямар ямар бодомжууд аналитик болохыг хэлснээр бид ‘ L_0 -ын хувьд аналитик’ гэдгийг тайлбарлаж байгаагаас ‘аналитик’, ‘. . .-нд аналитик’ гэдгийг тайлбарлаагүй. ‘ L ’-ийн хүрээг зохиомол хэлний аймгаар хязгаарлалаа ч, ‘ S ’, ‘ L ’ гэх хувьсагчууд бүхий ‘ S нь L -д аналитик байна’ гэх хэлцийг хараахан тайлбарлаагүй л байна.

Үнэндээ бид аналитик бодомжууд үнэн байх учиртай гэдгийг мэдэхэд хангалттай хэмжээнд, ‘аналитик’ гэдэгт байх учиртай тэр ач холбогдлын талаар мэдэж байгаа. Тэгвэл одоо тийм тийм бодомжууд аналитик гэж хэлдэггүй харин тийм тийм бодомжууд үнэнд нийцнэ хэмээдэг хоёр дахь хэлбэр бүхий утга зүйн дүрмийг авч үзье. Ийм дүрэм бол ‘аналитик’ хэмээх үл ойлгогдсон үгийг агуулдаг гэх шүүмжид өртөхгүй; бас үндэслэлдээ зориулаад ‘үнэн’ гэх илүү өргөн утга бүхий нэр томъёотой холбоотой хүндрэл байхгүй гээд үзье. Энэ хоёр дахь төрөлд хамаарах утга зүйн дүрэм буюу үнэний дүрэм бол хэлэнд буй бүх үнэнийг тусгайлан тогтоох албагүй; зүгээр л рекурсив эсвэл өөр ямар нэг байдлаар, тодорхой тооны бодомжийг, тодорхой болоогүй бусад бодомжуудын хамт үнэн хэмээн тооцох болзлыг л тавина. Тийм дүрмийг нэлээд тодорхой гэдгийг хүлээн зөвшөөрч болно. Үүнээс ургуулаад, аналитик чанарын хилийг дараах байдлаар татаж болно: аливаа бодомж (зүгээр л үнэн биш, харин) утга зүйн дүрмийн дагуу үнэн байх юм бол аналитик байна.

Гэсэн ч бидэнд ахиц гарсангүй. Одоо бол ‘аналитик’ хэмээх тайлбарлагдаагүй үгэнд хандахын оронд ‘утга зүйн дүрэм’ гэх тайлбарлагдаагүй холбоо үгт хандаж байна. Тодорхой ангид хамаарах бодомжуудыг үнэн хэмээж буй үнэн бодомж бүрийг утга зүйн дүрэм хэмээн тооцох аргагүй —үгүй бол утга зүйн дүрмийн дагуу гэдэг үүднээс, бүх үнэн “аналитик” болох байв. Утга зүйн дүрмүүдийг ‘Утга зүйн дүрмүүд’ гэх гарчиг дор байна гэх баримтын дагуу л зааглаж болох нь илэрхий; харин энэ гарчиг нь өөрөө утгагүй болж таарч байна.

Аливаа бодомж зөвхөн тийм тийм тусгайлан хавсаргасан “утга зүйн дүрмийн” дагуу үнэн бол L_0 -д аналитик байна гэж болох нь үнэн. Гэхдээ ингэвэл анх ярьж байсантай яг ижил тэр тохиолдол дээр эргээд очсоноо харах болно: “Зөвхөн . . . бол . . . L_0 -д аналитик байна.” ‘ S нь L -д аналитик’ гэдгийг хувьсагч ‘ L ’-ийн (‘ L ’-гэдгийг зохиомол хэлээр хязгаарлах явдлыг зөвшөөрсөн байлаа ч) хувьд ерөнхийгөөр тайлбарлахаар ээхэж буй үед ‘ L -ийн утга зүйн дүрмүүдийн дагуу үнэн’ гэх тайлбар ашиггүй байна; ‘. . .-ийн утга зүйн дүрэм’ гэх харьцангуй нэр томъёог тодруулах хэрэгцээ ‘. . .-нд аналитик’ гэдгийг тодруулах хэрэгцээнээс дутахааргүй их байна.

Зохиомол хэл L (ердийн хэлнээс ялгаатай нь) бол жирийн утгаар ойлгогдож буй хэл дээр онцгой утга зүйн дүрмүүдийг нэмсэн хувилбар мөн хэмээн эсэргүүцэж болохыг ойлгож байна —бүхлийг бүрдүүлэгч, эмх журам бүхий хослол гээ; бас тэгвэл L -ийн утга зүйн дүрмүүдийг L хослолын хоёрдох бүрдэл болохынх нь хувьд л тусгайлан тогтоох боломжтой. Гэвч, үүнтэй ижил бөгөөд илүү энгийн шалтгаанаар, зохиомол хэл L -ийг хоёрдогч бүрдэл нь аналитик бодомжуудын анги болдог эмх журам бүхий хослол хэмээн шууд ойлгож болно; тэгвэл L -ийн

аналитик бодомжуудыг *L*-ийн хоёр дахь бүрдэлд буй бодомжуудтай л адилаар тусгайлан тогтоох боломжтой болно. Эсвэл илүү дээр хувилбараар, бид зөвхөн өөрсдийнхөө хүчээр нөхцөл байдлыг дээрдүүлэх гэж зүтгэхээ больчихож болох юм.

Дээр аналитик чанарын талаар Карнапын бас түүний уншигчдын мэдэж байсан бүх тайлбарыг тус бүрчлэн авч үзсэнгүй. Гэхдээ бусад хэлбэрүүд рүү тэлж орсон явдлыг олж харах хэцүү биш. Заримдаа гарч ирдэг өөр нэг хүчин зүйлийг дурдах л шаардлагатай байна: утга зүйн дүрмүүд нь заримдаа ердийн хэл рүү орчуулах дүрмүүд байдаг, энэ тохиолдлуудад тэгэхээр зохиомол хэлний аналитик бодомжууд нь ердийн хэлэнд буусан тусгайлсан орчуулгынхаа аналитик чанарын улмаас аналитик хэмээн тооцогддог бөгөөд утга зүйн дүрмүүд бол үнэн хэрэгтээ орчуулгын дүрмүүд мөн.

Аналитик чанарын талаарх асуудлын өнцгөөс бол утга зүйн дүрэм бүхий зохиомол хэлний тухай ухагдахуун бол хамгийн сайн *төөрөлдүүлэгч дөл* (*feu follet par excellence*) мөн. Аналитик чанар хэмээх ухагдахууныг хэдийн ойлгочихсон үед л зохиомол хэлний аналитик бодомжуудыг тогтоож буй утга зүйн дүрмүүд бидний сонирхлыг татна; харин аналитик чанарыг ойлгоход дээрх дүрмүүд туслахгүй.

Хэрэв аналитик чанартай холбоотой оюуны, авир үйлийн эсвэл соёлын хүчин зүйлсийн — эдгээр нь юу ч байлаа гэсэн— хялбаршуулсан загвар ямар нэг байдлаар зураглагдсан бол зохиомлоор энгийн болгосон таамгийн шинжтэй хэлнүүдэд хандах нь аналитик чанарыг тодруулахад хэрэг болох байв. Харин аналитик чанарыг үл цомхотгогдох (*irreducible*) шинж дотор нь авч үзэж буй загвар бол аналитик чанарыг тодруулах асуудлыг гийгүүлнэ гэхэд хэцүү.

Үнэн гэдэг нь ерөнхийдөө бол хэлэнд бас хэлнээс гадуурх баримтуудаас хамаарч байдаг нь мэдээж. Хэрэв ертөнцөд тодорхой зүйлс одоогийнхоос өөр байсан бол ‘Брутус Цезарийг хороосон’ гэх бодомж худал болох байв. ‘Хороосон’ гэх үг ‘төрүүлсэн’ гэх утгыг илтгэдэг байсан бол дээрх бодомж бас л худал байх байсан. Бодомжийн үнэнийг ерөнхийд нь, ямар нэг байдлаар лингвистик бүрдэл хийгээд баримтын бүрдэлд задлах боломжтой хэмээн үзэх сорилт бий. Ингээд бодвол зарим бодомжуудын хувьд баримтын бүрдэл нь байдаггүй гэж үзэх учир байгаа мэт харагдана; харин тийм бодомжууд бол аналитик бодомжууд болж таарна. Гэвч, энэ бүх априори учир шалтгаан нь байгаад ч, аналитик болон синтетик бодомжуудын дунд зааг татсангүй. Татах ёстой тийм зааг ерөөс байна гэдэг нь өөрөө эмпирицистүүдын эмпирик бус догма буюу метафизик шинжтэй итгэл бишрэлийн өгүүлэл мөн.

V. ВЕРИФИКАЦЫН ОНОЛ БА РЕДУКЦИОНИЗМ

Энэ бараан зүйлсийг тунгаан бодох явцдаа бид эхлээд утга хэмээх ухагдахууны талаар, тэгээд танин мэдэхүйн ойролцоо утгын тухай, эцэст нь аналитик чанарын тухай бүдэгхэн авч үзлээ. Гэхдээ утгын талаарх верификацын онолын тухайд яах вэ хэмээн асууж болох юм. Энэ холбоо үг эмпирицизмийн лоозон болтлоо бэхэжсэн тул бид утга хийгээд түүнтэй холбогдох асуудлуудад таарах түлхүүрийг үүн дороос эрэхгүй бол тун ч шинжлэх ухаанч биш нэгэн мэт болж таарахад хүрчээ.

Пирсээс хойш алдартай болж ирсэн утгын талаарх верификацын онол нь аливаа бодомжийн утга бол түүнийг эмпирикээр батлах эсвэл няцаах арга юм хэмээн үздэг. Аналитик бодомж бол яаж ч байсан батлагдаж байдаг тийм хязгаарын тохиолдол мөн.

Нэгдүгээр хэсэгт дэвшүүлсэнчлэн, бид утгыг нэгж юм хэмээн үзэх асуудлыг алгасаад шууд утгын ижил байдал эсвэл ойролцоо утгын тухайд авч үзэж болно. Тэгвэл верификацын онол зөвхөн эмпирик баталгаа эсвэл няцаалтын арга зүйн талаас ижил төстэй байгаа бодомжууд л ойролцоо утгатай хэмээдэг болж таарна.

Энэ бол лингвистик хэлбэрийн танин мэдэхүйн ойролцоо утгыг ерөнхийд нь биш харин бодомжуудыг авч үзсэн баримтлал мөн.¹⁵⁷ Гэсэн хэдий ч, бодомжуудын ойролцоо утга хэмээх ойлголтоос гуравдугаар хэсгийн төгсгөлд авч үзсэнтэй тодорхой байдлаар, төстэй зүйлсийг бодолцон үзээд бусад лингвистик хэлбэрүүдийн ойролцоо утгын талаарх ойлголтыг гарган авч болно. Дурын хоёр хэлбэрийн аль нэгийг өөр ямар нэг бодомжид эзэлж буй нөгөөгийн байранд орлуулан тавихад (“үгс” доторх тохиолдлуудыг үл хамруулаад) ойролцоо утгатай бодомж гарч ирж байвал бид “үг” хэмээх ухагдахууныг авч үзээд тэр хоёрыг ойролцоо утгатай хэмээн тайлбарлаж болох нь үнэн. Эцэст нь, ойролцоо утга хэмээх ойлголт өгөгдсөн, улмаар лингвистик хэлбэрийн талаарх ойлголт ерөнхийдөө өгөгдсөн хэмээн үзээд нэгдүгээр хэсэгт гарсан шигээр, аналитик чанарыг ойролцоо утга хийгээд логик үнэний үүднээс тодорхойлж болно. Үүнтэй холбоотойгоор, аналитик чанарыг логик үнэний хамт бодомжуудын ойролцоо утга болохынх нь үүднээс илүү энгийнээр тодорхойлж болно; бодомжуудаас өөр лингвистик хэлбэрийн ойролцоо утгад хандах албагүй. Учир нь аливаа бодомжийг зүгээр л логикийн хувьд үнэн бодомжтой ойролцоо утгатай байгаа үед нь аналитик хэмээн дүрсэлж болно.

Тэгэхээр верификацын онолыг бодомжийн ойролцоо утгын талаарх зохистой баримтлал хэмээн зөвшөөрч болох юм бол аналитик чанарын талаарх ухагдахуун аврагдаж таарах нь. Гэхдээ, тунгаагаад үзье. Бодомжийн ойролцоо утгыг бодомжууд эмпирик баталгаа эсвэл няцаалтын аргын хувьд ижил төстэй байх явдал хэмээдэг. Харин ижил төсөөтэй байдлыг нь олохын тулд харьцуулаад буй энэ аргууд нь юу вэ? Өөрөөр хэлбэл, ямар нэг бодомж хийгээд түүний баталгаанд хувь нэмэр оруулж эсвэл саад хийж буй зүйл хоёрын дундах харилцааны уг чанар чухам юу вэ?

Уг харилцааны талаарх хамгийн гэнэн үзэл бол үүнийг шууд мэдээллийн харилцаа гэх үзэл мөн. Энэ бол *эрс редукционизм* юм. Энэ үүднээс утгатай бодомж бүрийг шууд туршлагын (immediate experience) талаарх бодомж (үнэн эсвэл худал) руу орчуулж болно хэмээн үздэг. Эрс редукционизм нь ямар нэг талаар утгын тухай верификацын онол гэгдэх зүйлийн илэрхий урьтал болдог. Ингээд Локк, Хьюм нар санаа бүр сэрэл мэдрэхүйн туршлагад шууд бий болдог эсвэл тэгж бий болсон санаануудаас бүрдсэн байх ёстой хэмээн үзжээ; бас бид Түүкээс¹⁵⁸ санаа аваад аливаа нэр томъёо ерөөс ач холбогдолтой (significant) байхын тулд сэрэл мэдрэхүйн дата-ны нэр эсвэл тийм нэрсийн нэгдэл, нэг бол тийм нэгдлийн товчлол байх ёстой хэмээн утга зүйн мэргэжлийн үг хэллэг ашиглах замаар арай өөрөөр хэлж болох юм. Ингээд хэлбэл, сэрэл мэдрэхүйн үйл явдал болж буй сэрэл мэдрэхүйн дата хийгээд сэрэл мэдрэхүйн шинж чанар болж буй сэрэл мэдрэхүйн дата хоёрын дундах хоёрдмол байдал энэ номлолын дотор үлдэнэ; бас нэгтгэлийн хүлээн зөвшөөрч болох арга замууд бүрхэг үлдэнэ. Түүгээр үл баран, энэ номлол хийж буй үгчилсэн шүүмжийнхээ үүднээс бидэнд шаардлагагүй бас тэвчих аргагүй тийм хязгаарлагдмал шинжтэй. Илүү учир шалтгаантайгаар, гэхдээ бас эрс редукционизм гэсэн зүйлийнхээ хязгаараас хэтрэлгүйгээр бүтэн бодомжуудыг өөрсдийнхөө ач холбогдолтой нэгжүүд хэмээн үзэж болно —тэгснээр бодомжуудаа бүхлээр нь сэрэл мэдрэхүйн дата-ны хэл рүү орчуулах боломжтой ч үг бүрчлэн орчуулах боломжгүй байдлыг шаардана.

Энэ засварыг Локк, Хьюм, Түүк нар найрсгаар хүлээн авах нь эргэлзээгүй авч түүхийн үүднээс харах юм бол ийм зүйл болохын тулд завсрын хоёр хөгжүүлэлт явагдахыг хүлээх хэрэгтэй. Энэ хөгжүүлэлтийн нэг нь бол верификац эсвэл баталгаажуулалт хэмээх утгын талаарх верификацын онол гэх зүйлтэй илэрхий хамт гарч ирсэн зүйлд илүү ач холбогдол өгөх болсон

¹⁵⁷ Бодомж биш нэр томъёонуудыг нэгж болгон аваад тус номлолыг боловсруулж болох нь үнэн. Тийм учраас И. Льюис нэр томъёоны утгыг “репрезентаци болсон эсвэл төсөөлөлд буй юмс нэг бол нөхцөл байдлуудын тухайд мөнөөх илэрхийллийг ашиглах эсвэл ашиглахаас татгалзах боломжийг бүрдүүлдэг оюун санааны шалгуур” хэмээн тодорхойлсон бий. (op. cit., p. I33).

¹⁵⁸ John Horne Tooke, *The Diversions of Purley* (London, 1776; Boston, 1806), I, ch. ii.

явдал байлаа. Верификац эсвэл баталгаажуулалтын объектуудыг бодомж хэмээн үзлээ ч, дээрх шиг ач холбогдол өгөх явдал нь бодомжийг ач холбогдол бүхий (significant) дискурсын нэгж болох үг эсвэл нэр томъёоноос илүү чухал болгожээ. Нөгөө нэг хөгжүүлэлт аваас эхнийхээс урган гарсан бөгөөд, хэрэглээнд тодорхойлогддог гүйцэд бус тэмдэг хэмээх ойлголтыг Рассел нээн илрүүлсэн явдал байв.

Ингээд эрс редукционизм бодомжуудыг нэгж хэмээн үзээд, сэрэл мэдрэхүйн дата-ны хэлийг тодруулж, ач холбогдолтой дискурсын үлдсэн хэсгийг тухайн хэл рүү бодомж бүрчлэн орчуулах аргыг харуулах үүрэг даалгавар өөртөө оноожээ. Карнап *Aufbau*-д энэ төслөө эхлүүлсэн байна.¹⁵⁹

Карнапын эхлэл цэгээ болгон авсан хэл нь сэрэл мэдрэхүйн хэл гэдгийн байж болох хамгийн явцуу утгад нийцэх тийм хэл биш байв. Учир нь тэр логикийн тэмдэглэгээнээс эхлээд дээд эрэмбийн олонлогийн онол хүртэлх зүйлсийг агуулсан хэл ашиглаж байлаа. Үр дүнд нь, түүний хэл цэвэр математикийн хэлийг бүхэлд нь агуулжээ. Уг хэлнээс салгаж боломгүй онтологи нь (өөрөөр хэлбэл хувьсагчуудынх нь утгын хүрээ /range of values/) зөвхөн сэрэл мэдрэхүйн үйл явдлуудаар зогсохгүй олонлог, олонлогуудын олонлогийг гэх мэтчилэн зүйлсийг өөртөө оруулжээ. Ийм суут ухаанд тээнэгэлзэх эмпирицистүүд бий. Логикоос гаднах, сэрэл мэдрэхүйн хэсэгтээ ч гэлээ Карнапын эхлэл цэг тун нарийн хямгач байгаа юм. Орчин үеийн логикийн нөөцийг машид ухаалгаар хэрэглэсэн цуврал байгуулалт хийхдээ тэр өмнө нь тийм өчүүхэн зүйлд тулгуурлаад тодорхойлчихно хэмээн хүмүүсийн зүүдэлж ч байгаагүй тийм чухал, өргөн хүрээ бүхий сэрэл мэдрэхүйн ойлголтуудыг тодорхойлж чадсан. Карнап бол шинжлэх ухааны шууд туршлагын нэр томъёонуудын цомхотгогдох байдалд (reducibility) сэтгэл үл ханан, цомхотголыг гүйцэтгэх нухацтай алхам хийсэн анхны эмпирицист байлаа.

Карнапын эхлэл цэгийг шаардлагад нийцсэн гэж үзлээ ч, хийсэн байгуулалт нь түүний өөрийнх нь хэлсэнчлэн бүтэн хөтөлбөрийн жижиг хэсэг төдий байв. Физик ертөнцийн талаарх хамгийн энгийн бодомжуудын байгуулалт хүртэл хар зураг төдий түвшинд л үлджээ. Энэ сэдвийн тухайд Карнап хэдий бүдэг бадаг боловч тун сайн санаа дэвшүүлсэн бий. Тэр цаг хугацаа-орон зайн мөч-цэгүүд гэдгийг бодит тоон дөрвөл болгон тайлбарлаж, сэрэл мэдрэхүйн чанаруудыг цэг-мөчүүдэд тодорхой ном журмуудын дагуу хамаатуулах тухайд авч үзсэн. Бүдүүн бааргаар тоймлон хэлэхэд, бидний туршлагатай таарамжтай байх хамгийн хялбар ертөнцийг гарган авах тийм байдлаар мөнөөх чанаруудыг цэг-мөчүүдэд хамаатуулахыг тэр зорьж байв. Туршлагаас ертөнцийг байгуулахад хамгийн бага үйлдэл хийх зарчим биднийг хөтлөх учиртай байсан юм.

Гэхдээ физик объектуудыг авч үзэж буй байдал нь хар зураг төдий гэдгээрээ зогсохгүй, зарчмын үүднээс цомхотгол болж дөнгөхгүй гэдгийг Карнап ойлгоогүй шиг байдаг. Түүний баримталж байсан ном журмын дагуу бол ‘ q хэмээх чанар нь x ; y ; z ; t цэг-мөчүүд дээр байна’ гэх хэлбэр бүхий бодомжуудын үнэний утга нь тодорхой бүрдлүүдийг нийтэд нь боломжит дээд бас доод хэмжээнд аваачих тийм байдлаар хуваарилагдах, бас туршлага нэмэгдэхийн хэрээр үнэний утгууд нь мөн ялгаагүй дэвшилттэйгээр шинэчлэгдэж байх учиртай байв. Энэ бол шинжлэх ухаан чухам юу хийдгийг харуулсан сайн схем (зориудаар хэт хялбаршуулсан гэдгийг бататгаж хэлье) гэж би бодож байна; гэхдээ энэ нь ‘ q хэмээх чанар нь x ; y ; z ; t цэг-мөчүүд дээр байна’ гэх хэлбэр бүхий бодомжийг хэрхэн Карнапын сэрэл мэдрэхүйн дата¹⁶⁰ ба логикийн анхдагч хэл рүү орчуулж болох талаар хар зураг төдий заавар ч өгдөггүй. ‘Дээр байна’ гэх холбоос нэмэлт бөгөөд

¹⁵⁹ R. Carnap, *Der logische Aufbau der Welt* (Berlin, 1928).

¹⁶⁰ Орчуулагчийн тэмдэглэл: “Data” гэх үгийг “өгөгдөл” хэмээн орчуулдаг ч “sense data” буюу сэрэл мэдрэхүйн дата-ны тухай ярьж буй өгөгдөл гэх үгийг ашиглах нь эргэлзээ төрүүлж магад хэмээн үзээд “дата” гэж галиглаж буулгав.

тодорхойлогдоогүй холбоос хэвээр үлдэв; ном журмууд бидэнд үүнийг үгүй хийх биш харин хэрэглэхийг зөвлөдөг.

Карнап сүүлд нь энэ санааг үнэлсэн шиг харагддаг; сүүл үеийн бичвэрүүддээ тэрээр физик ертөнцийн талаарх боломжуудыг шууд туршлагын талаарх бодомжууд руу орчуулах боломжийн тухай ухагдахууныг орхисон байна. Эрс хэлбэртээ буй редукционизм Карнапын философид тусгал олохоо хэдийн больжээ. Гэхдээ редукционизмын догма харьцангуй зөөлөн бөгөөд сул хэлбэрээрээ эмпирицистүүдын бодолд нөлөөлсөн хэвээр байна. Бодомж тус бүрд, эсвэл синтетик бодомж тус бүрд холбогдох, алийнх нь ч гарч ирсэн тохиолдол тухайн бодомжийн үнэн байх магадлалд хувь нэмэр оруулдаг тийм өвөрмөц хүрээ бүхий бололцоот сэрэл мэдрэхүйн үйл явдлууд, бас гарч ирсэн тохиолдол нь мөнхүү магадлалыг бууруулж байдаг өвөрмөц хүрээ бүхий бололцоот сэрэл мэдрэхүйн үйл явдлууд байдаг гэх ухагдахуун салаагүй байна. Энэ ухагдахууныг утгын талаарх верификацын онолоос салгаж болшгүй нь ойлгомжтой.

Бодомж тус бүрийг бусад бодомжуудаас нь салган авч үзээд ерөөс баталгаа эсвэл няцаалтад оруулж болно хэмээх үзэлд редукционизм үлджээ. Харин би үүнд сөргүүлэн, Карнапын *Aufbau*-даа бичсэн физик ертөнцийн талаарх номлолоос гол санаагаа авч, гадаад ертөнцийн талаарх бодомжууд маань сэрэл мэдрэхүйн шүүхтэй хувь бүрчлэн биш ямагт хамтаараа нүүрэлдэж байдаг гэх санааг дэвшүүлж байна.

Редукционизмын догма нь хүчгүй болсон хэлбэртээ хүртэл, аналитик хийгээд синтетикийн дунд зааг байна гэх нөгөө догматайгаа тун ойр холбоотой. Бид хоёрт дурдсан энэ догманаас утгын талаарх верификацын онолоор дамжаад редукционизмын догма руу зүглэсэн. Шулуухнаар хэлбэл, нэг догма нь нөгөөгөө дараах замаар дэмждэг нь тодорхой байна: аливаа бодомжийг баталгаажуулах эсвэл няцаах тухай ярихыг ерөнхийд нь ач холбогдолтой хэмээн үзэж буй цагт, яаж ч байсан утгагүйгээр (*vacuously*) бас гарцаагүй (*ipso facto*) батлагддаг тийм хязгаарлагч төрлийн бодомжийн талаар ярих нь ач холбогдолтой харагдана; харин тийм бодомж бол аналитик бодомж мөн.

Хоёр догмын үндэс нь ижил гэдэг нь үнэн. Бид бодомжуудын үнэн нь ерөнхийгөөрөө, хэл болон хэлнээс гаднах баримтын аль алиас гарцаагүй хамаарч таардгийг сая үзлээ; бас энэ илэрхий нөхцөл байдал нь бодомжийн үнэнийг ямар нэг байдлаар лингвистик хийгээд баримтын бүрдлүүдэд задлаж болно гэх сэтгэгдлийг логикийн үүднээс биш харин дэндүү ердийн байдлаар тээж явдгийг онцолсон. Хэрэв бид эмпирицист бол, баримтын бүрдэл нь тодорхой хүрээ бүхий баталгаажуулагч туршлагатай дүйх ёстой. Лингвистик бүрдэл л дангаараа чухалд тооцогдох тийм эрс тохиолдолд бол үнэн бодомж нь аналитик байна. Гэхдээ одоо бол аналитик хийгээд синтетикийн дундуур зааг татаж үнэхээр болохгүй байгааг тод харсан хэмээн найдаж байна. Ваарт буй хар, цагаан бөмбөгнүүдийн талаарх урьдчилан бэлтгэсэн жишээнүүдээс үл хамааран, синтетик бодомжийн эмпирик баталгаажуулалтын талаарх нарийн тодорхой онолд хүрэх асуудал цаг ямагт бэрх байж ирснийг би бас гүнээ гайхаж байна. Одоо дэвшүүлж буй санаа маань дээрхийг утгагүй зүйл хэмээж байгаагаас гадна тийм утгагүй зүйлийн үндэс болох дангаараа буй ямар ч бодомжийн үнэнд лингвистик хийгээд баримтын бүрдэл байдаг хэмээн ярих явдлыг бас утгагүй хэмээж байна. Нэгтгээд аваад үзвэл, шинжлэх ухаан туршлага хийгээд хэлний аль алиас хамааралтай; гэвч шинжлэх ухааны бодомжуудыг нэг нэгээр нь авч үзэх байдлаар энэ хоёрдмол талыг мөшгөх боломжгүй.

Тодорхойлолтын талаарх Расселын ойлгоц бол нийтлэг хэрэглээндээ, Локк, Хьюм нарын нэр томъёо бүрчилсэн (*term by term*) эмпирицизмийн боломжгүй байдлаас давж гарсан явдал байсныг өмнө онцолсон. Расселыг дагаад, нэр томъёо биш бодомж нь эмпирицист шүүмжийн найдаж болох нэгж болж ирэв. Гэхдээ би энд бодомжийг нэгж хэмээн үзэхдээ ч бид тороо дэндүү нарийн зуржээ хэмээн мэдэгдэж байна. Эмпирик ач холбогдол бүхий нэгж бол бүхэл шинжлэх ухаан өөрөө мөн.

VI. ДОГМАГҮЙ ЭМПИРИЦИЗМ

Газар зүй хийгээд түүх зэргийн хамгийн энгийн асуудлуудаас эхлээд атомын физикийн хамгийн гүн хуулиуд эсвэл цэвэр математик, логик хүртэл мэдлэг эсвэл итгэл үнэмшил гэдэг зүйлс маань бүхэлдээ туршлагын зах орчимд л нөлөөлж байдаг хүний бүтээсэн зүйл мөн. Арай өөрөөр хэлбэл, бүхэл шинжлэх ухаан бол туршлага хэмээх хязгаарын нөхцөлтэй (boundary conditions) хүчний талбар мэт юм. Зах хэсгээр нь гарч буй туршлагатай мөргөлдөх тохиолдлууд талбарын дотоодод өөрчлөлт оруулна. Бидэнд буй зарим бодомжийн үнэний утга шинээр хуваарилагдах учиртай. Бодомжуудын хоорондох логик холбооны улмаас зарим бодомжуудыг дахин үнэлэх явдал бусдыг нь ч бас дахин үнэлэх явдлыг дагуулна — логикийн хуулиуд нь өөрсдөө тухайн тогтолцоонд буй тодорхой бодомжууд буюу талбарт буй өөр элементүүд мөн. Нэг бодомжийг дахин үнэлсэн бол бид өөр заримыг нь эхний бодомжтой логикийн хувьд холбогдсон эсвэл өөр хоорондоо логикийн хувьд холбоотой эсэхээс үл хамаараад тэдгээрийг ч бас дахин үнэлэх ёстой. Гэхдээ талбар бүхэлдээ бол хязгаарын нөхцөл болох туршлагаар огтоос тодорхойлогдохгүй бөгөөд аливаа зөрчилт туршлага гарч ирэх үед аль бодомжийг дахин үнэлэх тухайд өргөн хүрээний сонголт бий. Талбарт бүхэлд нь нөлөөлж буй тэнцвэрт байдлаар дамжих шууд бус холбооноос бусдаар, талбарын дотоодод ямар ч тусгаар (particular) туршлага ямар нэг тухайлсан бодомжтой холбоотой байхгүй.

Хэрэв ингэж үзэх нь зөв бол нэгж бодомжийн — тэр тусмаа энэ нь талбарын зах болж буй туршлагаас хол бодомж бол — эмпирик агуулгын тухай ярих нь алдаа болно. Түүнчлэн туршлагаас хамаараад тохиолдлын шинжтэйгээр хүчинтэй байдаг синтетик бодомжууд хийгээд юу ч болж байсан хүчинтэй байдаг аналитик бодомжуудын дундаас зааг эрэх нь мунхаг явдал болно. Хэрэв тогтолцооны бусад хэсэгт нь хангалттай эрс өөрчлөлт хийх юм бол ямар ч бодомж юу ч болж байсан хүчинтэй байж болно. Зөрчил бүхий туршлагатай (recalcitrant experience) тулгарсан үед хий юм харах эсвэл логикийн хууль гэгддэг тодорхой бодомжуудыг засварлах замаар захад маш ойр бодомжийг хүртэл үнэн хэмээж болно. Нөгөө талдаа бас дээрхтэй ижил шалтгаанаар ямар ч бодомж хянан засварлалтаас ангид биш байна. Бүр гуравдагчийг үгүйсгэх логикийн хуулийг хянан засварлах явдлыг Квантын механикийг хялбаршуулах арга зам болгон дэвшүүлдэг; тэгээд зарчмын хувьд энэ нь Кеплер Птолемейг халсан шилжилт, эсвэл Эйнштейн Ньютоныг, Дарвин Аристотелийг халсан шилжилтүүдээс юугаараа өөр гэж?

Яриагаа тодорхой байлгахын тулд би сэрэл мэдрэхүйн зах хэсэгт ойртож бас холдож ирлээ. Харин одоо энэ ухагдахууныг зүйрлэл ашиглалгүйгээр тодруулах гээд үзье. Тодорхой бодомжууд сэрэл мэдрэхүйн туршлага биш физик объектын тухай байлаа ч сэрэл мэдрэхүйн туршлагад өвөрмөц байдлаар таардаг (germane) мэт харагдана — бас энэ таарамж нь зарим бодомжууд зарим туршлагад, үлдсэн бодомжууд бусдад нь гэх мэт сонгомол хэлбэртэй байна. Тийм бодомжуудыг, тэр дундаа тухайлсан туршлагуудад холбогддогийг нь би захад ойр хэмээж байгаа. Гэхдээ бодит байдал дээр би энэ “таарагч шинж”-ийн харилцаагаар зөрчилт туршлагын үйл явдалтай холбоотойгоор нэг биш нөгөө бодомжийг хянан засварлахаар сонгох харьцангуй шинжтэй магадлалаас илүүг авч үзээгүй. Жишээ нь, биднийг элм гудамжинд тоосгон байшин байдаг гэх бодомжийг л уг сэдэвтэй холбогдох бусад бодомжуудтай хамт дахин үнэлэх замаар тогтолцоогоо нийцүүлэхэд гарцаагүй хүргэж таарах зөрчилт туршлагын тухайд төсөөлж болно. Цэнтаур байхгүй гэх бодомжийг үүнтэй төстэй бодомжуудтай хамт дахин үнэлэх замаар тогтолцоогоо нийцүүлэхэд хүргэх өөр зөрчилт туршлагуудын талаар төсөөлж болно. Бүхэл тогтолцооны өөр өөр хороонд өөр өөр дахин үнэлгээ хийх замаар зөрчилт туршлагыг нийцүүлж болох талаар би хэдийн мэтгэсэн; гэхдээ, одоо бидний төсөөлж үзэж буй тохиолдлууд дээр бол бүхэл тогтолцоонд аль болох бага саад учруулах гэсэн ердийн хандлага маань биднийг тоосгон байшин, цэнтаур зэргийг агуулж буй дээрх тухайлсан бодомжуудыг хянан засварлах явдал дээр анхаарлыг маань аваачна. Энэ бодомжууд нь эмпирик заагч чанараараа онтологи, логик эсвэл

физикт байх маш онолын шинжтэй бодомжуудаас хамаагүй тод гэж санагдана. Маш онолын шинжтэй гэсэн дээрх бодомжуудыг бүхэл сүлжээний харьцангуй төв хэсэгт байрласан гэж болох бөгөөд энэ нь ямар нэг тухайлсан сэрэл мэдрэхүйн дата-тай үүсгэсэн сонгомол холбоо тун өчүүхэн цухуйж байна гэсэн үг юм.

Би эмпирицист болохынхоо хувьд шинжлэх ухааны ойлголтын схемийг өнгөрсөн туршлагуудын үндсэнд ирээдүйн туршлагуудын урьдчилан таамаглах хэрэгсэл гэдгийг нь бүрэн хүлээн зөвшөөрсөөр байх болно. Физик объектууд зохих дамжлага болохынхоо хувьд тухайн нөхцөл байдал руу ойлголт болон орж ирдэг —туршлагад тулгуурласан тодорхойлолт болохынхоо хувьд биш харин эпистемологийн үүднээс Гомерын бурхадтай харьцуулж болох, үл цомхотгогдох позит (posit) болохынхоо хувьд. Би лав мэргэжлийн бус физикч болохынхоо хувьд Гомерын бурхад биш физик объектуудад итгэдэг; бас ингэж итгэхгүй байх явдлыг шинжлэх ухааны хувьд алдсан хэрэг гэж үзнэ. Гэхдээ эпистемологийн суурийн тухайд бол физик объектууд хийгээд бурхад нь төрлөөрөө биш харин зэргээрээ л ялгаатай. Аль аль нь соёлын позит болохынхоо хувьд л бидний ойлгоцод орж ирдэг. Физик объектуудын домог илүү хянагдаж болох тогтолцоог туршлагын урсгалаас гаргах үр дүнтэй хэрэгсэл гэдэг нь батлагдсан учраас эпистемологийн хувьд хамаг л бусад домгоос илүү дээр юм.

Рационал тоонууд өгөгдсөн байна гээд төсөө болгох үүднээс бодоод үзье. Бид тухайн зүйлсийн талаар эргэцүүлэхийн тулд алгебрын онол хөгжүүлсэн ч тодорхой язгуур дор квадрат гэх мэт зарим үйлдэл зарим үндэслэгээнд утгагүй байсан учраас мөнөөх онол дэндүү нарийн төвөгтэй байв. Тэгээд онтологио иррационал тоонууд гэх нэг төрөл домгийн юмсаар баяжуулах замаар алгебрын дүрмүүдээ хамаагүй хялбаршуулж болохыг нээн илрүүллээ. Бид юу юунаас илүүтэйгээр рационал тоонуудад сонирхол татагдсан хэвээр байгаа; гэхдээ иррационал тоонуудыг бас байгаа хэмээн үзсэнээр рационал тооны талаарх нэг хуулиас өөр нэгийг нийтлэг байдлаар тун богино хугацаанд бас хялбархан гарган авч болохыг олж мэдсэн.

Би үүнийг иррационал тоонууд хийгээд тооллын системийн бусад өргөтгөлийн талаарх удиртгал болгоход тун боломжийн баримтлал гэж үзэж байна. Иррационал тооны домгийн байр суурь нь эцэстээ Дедекинд-Расселын иррационал тоонууд харьцаануудын хязгааргүй ангид хүрэх замыг нээж өгсөн явдал бол миний төсөө болгож буй зүйлтэй хамаагүй. Бодит байдлыг рационал тооны ангиуд руу тэлж оруулалгүй зөвхөн рационал тоогоор хязгаарлаж байгаа үед Дедекинд-Расселын иррационал тоонууд байх боломжгүй.

Харин одоо би туршлага бол рационал тоонуудтай ижил төсөөтэй, харин физик объектууд нь иррационал тоонуудтай ижлээр туршлагыг авч үзэх байдлыг маань хялбаршуулах л үүрэгтэй позитууд мөн гэх санааг дэвшүүлж байна. Физик объектуудыг туршлага руу цомхотгох боломж иррационал тоонуудыг рационал тоо руу цомхотгох боломжоос илүү биш ч гэлээ тэдгээрийг онолдоо багтааснаар туршлагын талаарх нэг бодомжоос нөгөөд амархан хүрэх боломжийг гарган өгнө.

Физик объектуудыг позит хийх болон иррационал тоонуудыг позит хийх хоёрын дунд хоёр л ялгаа байгаа гэж бодож байна. Нэгдүгээрт, физик объектуудын хувьд хялбаршууллын хүчин зүйл тооллынхоос давсан хүчтэй байна. Хоёрдугаарт, физик объектуудыг позит хийх явдал нь нөгөөгөөсөө хамаагүй эртнийх бөгөөд хэлтэй хамт үүссэн гэж би бодож байна. Учир нь хэл нийгмийн шинжтэй бөгөөд хөгжил нь интерсубъектив заагч чанараас хамаарч байдаг.

Позит хийх явдал нь нүдэнд үзэгдэх физик объектуудаар хязгаарлагдахгүй. Нүдэнд үзэгдэх объектуудын талаарх хуулиудыг гаргахын тулд атомын түвшний бас түүнээс ч жижиг объектуудыг позит хийдэг бөгөөд туршлагын хуулиуд аваас хамаагүй энгийн бөгөөд зохицуулахад хялбар юм; бас атомын болон суб-атомын түвшний юмсыг нүдэнд харагдах юмсаар бүрэн тодорхойлох явдлыг нүдэнд харагдах юмсыг сэрэл мэдрэхүйн дата-гаар тодорхойлох явдлаас илүүгээр хүлээх эсвэл шаардах хэрэггүй. Шинжлэх ухаан бол эрүүл ухааны

(common sense) үргэлжлэл мөн. Бас энэ нь онолыг хялбаршуулахын тулд онтологийг тэлэх эрүүл ухааны аргыг үргэлжлүүлдэг.

Том, жижиг физик объектууд л зөвхөн позитууд биш. Хүч (force) бол позитын өөр нэг жишээ мөн; бас энерги, матери хоёрын дунд зааг тавих явдал өнөө хоцрогдсон нь үнэн. Түүгээр үл баран, математикийн гол агуулга болсон хийсвэр юмс ч — ангиуд, ангиудын ангиуд гэх мэт — бас позитууд мөн. Эпистемологийн хувьд эдгээр нь физик объектууд болон бурхадтай яг л ижилхэн суурь бүхий домгууд юм. Эдгээр нь сэрэл мэдрэхүйн туршлагатай харьцах явдлыг түргэсгэх зэргээсээ бусдаар нэг нэгнээсээ сайн ч, муу ч биш.

Рационал болон иррационал тооны ерөнхий алгебр нь рационал тооны алгебраас хамаарч байгаа ч гэлээ түүнээс толигор бөгөөд эвтэй юм; харин рационал тооны алгебр бол үүний арзгар бөгөөд эвгүй хэсэг нь мөн. Математикийн, байгалийн, хүмүүнлэгийн шинжлэх ухаан бүхэлдээ дээрхтэй ижил хэлбэрээр, гэхдээ бүр ч илүүтэйгээр туршлагаас хамаарч байдаг. Тогтолцооны ирмэгийг туршлагаар хүрээлэх ёстой; харин үлдсэн хэсэг нь бүхий л нарийн нягт домог хийгээд зохиолтойгоо хамт хуулийг хялбаршуулах үүрэгтэй.

Энэ үзлийн өнцгөөс онтологийн асуудлууд байгалийн шинжлэх ухаантай эн зэрэгцэнэ. Нүүрний хувирлын ангиудыг юмс гэж үзэх эсэх тухай асуудлыг бодоод үзье. Энэ бол миний өөр нэг газар бичсэнчлэн¹⁶¹ ангиудыг утга (value) болгож авдаг хувьсагчуудыг квантчилах эсэх тухай асуудал мөн. Харин Карнап энэ асуудлыг баримтаас хамаарах биш харин хэлний эвтэй хэлбэрийг буюу шинжлэх ухаанд эвтэй байх ойлголтын схем эсвэл ерөнхий бүдүүвчийг сонгох тухай асуудал гэж үзсэн хэвээр үлджээ.¹⁶² Энэ нь шинжлэх ухааны таамаглалд ч нийтэд нь ижилхэн хамаатай гэдэг болзлыг зөвшөөрөх юм бол би түүний дээрх санаатай санал нийлж байгаа. Карнап аналитик, синтетик хоёрын дундуур туйлын зааг татаж байж л онтологийн асуудлууд хийгээд шинжлэх ухааны таамаглалд тавьсан хоёр өөр жишгийг хадгалж үлдэх боломжтойгоо ухаарчээ¹⁶³; харин би тэрхүү заагаас татгалзаж байгаа гэдгээ дахин хэлэх хэрэгтэй байна.

Зарим асуудал эвтэй ойлголтын схемд илүү ойр бас зарим нь үл тайлбарлагдах баримтад (brute fact) илүүтэй хамаардаг мэт байдгийг би зөвшөөрнө. Ангиуд байдаг эсэх тухай асуудал эвтэй ойлголтын схемд илүүтэй холбогдох асуудал шиг харагдана; цэнтаур эсвэл Элм гудамд байх тоосгон байшингийн асуудал бол баримтын асуудалд илүү ойр санагдана. Гэхдээ би үүнийг зэргийн л ялгаа бөгөөд энэ нь тухайлсан нэг зөрчилт туршлагад шинжлэх ухаан гэх нэхмэлийн нэг биш нөгөө утсыг тааруулах бүдэг бадаг прагматик хүсэл сонирхлоос маань хамаарч байдаг хэмээн үзэж байна. Ийм сонголтуудад, энгийн байдлын (simplicity) эрэлд ч бас консерватив үзэл тусгалаа олдог.

Карнап, Льюис болон бусад хүмүүс хэлний хэлбэр буюу шинжлэх ухааны ерөнхий бүдүүвчүүд дундаас сонгох эсэх тухай асуудал дээр прагматик байр суурьтай байжээ; гэхдээ аналитик, синтетикийн дунд байх төсөөллийн шинжтэй зааг дээр ирэхээр тэдний прагматизм алга болчихдог. Тэр заагаас татгалзахдаа би прагматизмтай илүү ойр байдаг. Хүн бүрд шинжлэх ухааны өв бас тасралтгүй гарч ирэх сэрэл мэдрэхүйн цочроолыг тогтоох далан өгөгдсөн бий; харин аливаа хүн шинжлэх ухааны өвөө тасралтгүй гарч ирж буй сэрэл мэдрэхүйн даланд нийцүүлэх явцад чиглүүлэг болж буй бодлууд нь рационал байх үедээ прагматик байна.

¹⁶¹ E.g., in "Notes on Existence and Necessity," Journal of Philosophy, XL (1943), 13-127...

¹⁶² "Carnap, "Empiricism, Semantics, and Ontology," Revue internationale de philosophies IV (0950), 20-40

¹⁶³ Op. cit., p. 32, footnote